



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

додог оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/84

Улаанбаатар хот

44 дүгээр цэцэрлэгийн харьяа “Алтай”
бүлгийн засварын ажилд хяналт тавих
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж” хөтөлбөрийн хөрөнгөөр хийгдэж буй 44 дүгээр цэцэрлэгийн харьяа “Алтай” бүлгийн засварын ажлын гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Гишүүд:

Б.Цогжавхлан

Д.Хүрэлбаатар

Н.Тунгалаг

С.Батбаясгалан

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Тохижилт, худалдаа үйлчилгээний
хэлтсийн дарга

44 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

Боловсролын хэлтсийн Хүүхдийн
эрх, хөгжил, хамгаалал, сургалтын
орчин, сурах бичиг, хоол үйлдвэрлэл
хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг:

Б.Нямгарав

Нийгмийн хөгжлийн хэлтсийн
мэргэжилтэн

2. Хяналт тавих ажлыг үр дүнтэй зохион байгуулж 14 хоног тутамд эргэн танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД